

БАТЛАВ.  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

..... Д.СУМЪЯАБАЗАР

2023 оны ... сарын ... өдөр



## **НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН 2023-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

## АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	5
ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ .....	5
ГУРАВ. АЛСЫН ХАРАА .....	17
ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО .....	17
ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ .....	17
ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО .....	22
ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН .....	24
НАЙМ. НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛ .....	26
Хүснэгт 1. Мандатын шинжилгээний хүснэгт хуулийн заалтаар	
Хүснэгт 2. Мандатын шинжилгээ: Хуулиуд	
Хүснэгт 3. Чиг үүргүүд	
Хүснэгт 4. Оролцогч талуудын оролцоо	
Хүснэгт 5. Чиг үүргийн үнэлгээ	
Хүснэгт 6. Захиргааны хэм хэмжээ	
Хүснэгт 7. Салбарт хэрэгжиж буй төсөл арга хэмжээ	
Хүснэгт 8. Нийтийн тээврийн газрын орчны шинжилгээ - <b>SWOT</b>	
Хүснэгт 9. Стратегийн зорилго, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин	
Хүснэгт 10. Стратегийн зураглал	

Зураг 1. Оролцогч талууд

Зураг 2. Google form-аар авсан чиг үүрэг дахин хуваарилах аргачлалын маягтын дагуу боловсруулсан санал асуулгын загвар  
Зураг 3. Google form-аар авсан чиг үүрэг дахин хуваарилах аргачлалын маягтын дагуу боловсруулсан санал асуулгын загвар

Зураг 4. Google form-аар авсан санал асуулгын дүн 1 Зураг

5. Google form-аар авсан санал асуулгын дүн 2 Зураг 6.

Санал асуулгад оролцогчид

Зураг 7. Нийтийн тээврийн газрын бүтцийн схем

Зураг 8. Стратегийн уялдаа

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Төрийн байгууллагад орц, үйл явцаас илүү гарц, үр дүнд чиглүүлэн удирдах арга барилд шилжих чиг хандлага бий болсон үеэс стратегийн удирдлагын үзэл санаа төрийн салбарт хөгжин дэлгэрч төрийн байгууллага стратегийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх болсон.

Манай улсын төрийн захиргааны шинэчлэлийн хүрээнд Улсын Их Хурал 1996 онд "Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичгийг 38 дугаар тогтоолоор батлан мөрдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлаар "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль"-ийг 2020 онд шинэчлэн баталсан. Уг хуульд зааснаар Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг үндэслэн аймаг, нийслэлийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулна.

Нийтийн тээврийн газрын хувьд дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь тэдгээрт нийцүүлэн боловсруулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө байна.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/667 дугаар захирамжаар "Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө" батлагдсан бөгөөд уг захирамжаар Нутгийн захирагааны байгууллагуудын стратеги төлөвлөгөөг боловсруулах үүргийг өгсөн байдаг тул Нийтийн тээврийн газрын стратеги төлөвлөгөөг боловсруулах шаардлага үүсэж байна.

Монгол Улсын Засгийн газраас "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам" батлах тухай Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоол, мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар "Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу Нийтийн тээврийн газрын 2023-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсрууллаа.

## ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандат нь тухайн байгууллагад хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээтэй холбоотой байдаг. Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан чиг үүрэг дахин хуваарилах аргачлалд тусгаснаар "чиг үүрэг" гэдэг нь төрийн байгууллагад хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнд тодорхой үр дүнд хүрэх зорилгоор хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тогтвортой чиглэл юм. Нийслэлийн стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд мандатын буюу чиг үүргийн шинжилгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам", ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг тус тус мөрдлөг болгосон.

**Алхам 1.** Нийтийн тээврийн газрын үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг тодорхойлох.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны А/88 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нийтийн тээврийн газрын дүрэм”-ийн 1.1-д “Нийслэлийн Нийтийн тээврийн газар” (цаашид “Газар” гэх) нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтууд, Нийслэлийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн нийгэм, эдийн засгийн зорилтууд болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргаас нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх талаар баримтлах бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг мөн.” гэж зааж өгсөн.

Нийслэлийн нийтийн тээврийн газрын мандатыг тодорхойлохдоо одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2020), Автотээврийн тухай хууль (1999), Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль (2021), Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/24 дүгээр тушаалаар баталсан “Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрэм”, “Автотээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх дүрэм” болон бусад хууль тогтоомжийг үндэслэсэн.

Эдгээр хууль тогтоомжоос Нийслэлийн нийтийн тээврийн газрын үйл ажиллагаанд хамаарах ерөнхий болон үндсэн чиг үүргийг тодорхойлж, үйл ажиллагааны чиглэлээр нь ангилав.

Нийслэлийн нийтийн тээврийн газрын үйл ажиллагаатай холбоотой 52 орчим хууль байгаа бөгөөд эдгээрээс үзвэл үндсэн чиг үүрэг 23, дэд чиг үүргийн хувьд 29 байна. Үүнийг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй байдлаар харуулав.

### Хүснэгт 1. Мандатын шинжилгээний хүснэгт хуулийн заалтаар

Д/д	Чиг үүрэг	Хуулийн заалт
	Ерөнхий чиг үүрэг 1. НЗД-ын Орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх: Нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн талаар баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх	
1.1.	Нийслэлийн нийтийн тээвэр, такси үйлчилгээний зохицуулалт;	МУЗЗНДНТУТХ 24.1.11.
1.2.	Олон улсын зорчигч болон ачаа тээвэр, логистикийн үйл ажиллагааны удирдлага, зохицуулалт	МУНУБХЭБТХ 8.2.3
1.3.	Автотээврийн талаар төрөөс баримтлах бодлоготой уялдуулан тухайн нутаг дэвсгэрт автотээврийн талаар баримтлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;	АТТХ 7.1.2
1.4.	Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран нутаг дэвсгэртээ автотээврийн улсын хяналт хэрэгжүүлэх;	АТТХ 7.1.3
1.5.	Нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэрт зохицуулах, зохион байгуулах;	АТТХ 7.1.4
1.6.	8.4.Аймаг хооронд, орон нутаг, аймгийн төв, хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг тухайн аймаг, хотын Засаг дарга гаргах бөгөөд аймаг, нийслэлийн Засаг даргын эрх олгосон байгууллага хэрэгжүүлнэ.	АТТХ 8.4
1.7.	20.1.Автотээврийн салбарын үйл ажиллагаанд тавих захиргааны хяналтыг автотээврийн хяналт, шалгалтын асуудал эрхэлсэн төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын мэргэжлийн хяналтын алба, автотээврийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.	АТТХ 20.1

## Хүснэгт 2. Мандатын шинжилгээ: Хуулиуд

Дд	Хуулиуд
<b>Байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах хуулиуд</b>	
1.	АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ
2.	АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ
3.	АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ
4.	АХМАД НАСТНЫ ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
5.	БОЛОВСРОЛЫН ТУХАЙ
6.	ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬ
7.	ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
8.	ЗӨРЧЛИЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
9.	ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
10.	ИРГЭНИЙ ХУУЛЬ
11.	ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
12.	МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ
13.	НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ
14.	НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ 2022.05.01-нээс
15.	ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ
16.	ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ
17.	ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ
18.	ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ
19.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ
20.	ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ
21.	ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
22.	ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ ХУУЛЬ
23.	ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ
<b>Салбарын үйл ажиллагаанд хэрэглэгдэх, дэд чиг үүрэгт хамаарах хуулиуд</b>	
1.	АУДИТЫН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
2.	БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
3.	ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ
4.	ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ
5.	ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ
6.	ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ
7.	ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
8.	ИННОВАЦИЙН ТУХАЙ
9.	КОМПАНИЙН ТУХАЙ
10.	КОНЦЕССЫН ТУХАЙ
11.	КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ

12.	МОНГОЛ УЛСЫН АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬ
13.	МОНГОЛ ХЭЛНИЙ ТУХАЙ
14.	МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ
15.	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ
16.	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
17.	ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
18.	ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ
19.	ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬ
20.	ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ
21.	ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ
22.	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ
23.	ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ
24.	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ
25.	ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
26.	ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
27.	ХЭМЖИЛ ЗҮЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
28.	ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
29.	ШУУДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ

### Хүснэгт 3. Чиг үүргүүд

Ерөнхий чиг үүрэг: НЗД-ын Орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх: Нутаг дэвсгэрийн хэмжээнд тээврийн талаар баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх			
Дд	Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран оролцогч байгууллагууд
1.	Автотээврийн талаар төрөөс баримтлах бодлоготой уялдуулан тухайн нутаг дэвсгэрт автотээврийн талаар баримтлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;	Тээвэр, хөдөлгөөн зохион байгуулалтын бодлого, төлөвлөлттэй уялдуулан нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	НЗДТГ, ТЦАын ЗЦГ, ЗХУТ
		Хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээнд байгалийн шатдаг хий, цахилгаан эх үүсвэрээр ажилладаг автотээврийн хэрэгсэл ашиглах.	ЗТХЯ, НЗДТГ

2.	Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран нутаг дэвсгэртээ автотээврийн улсын хяналт хэрэгжүүлэх;	Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран нутаг дэвсгэртээ автотээврийн улсын хяналт хэрэгжүүлэх	ЗТХЯ, МХЕГ, НМХГ
		Автотээврийн салбарын үйл ажиллагаанд тавих захиргааны хяналтыг автотээврийн хяналт, шалгалтын асуудал эрхэлсэн төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын мэргэжлийн хяналтын алба, автотээврийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлэх.	ЗТХЯ, МХЕГ, НМХГ
		Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажлыг зохион байгуулах;	ЗТХЯ
		Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журмыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах	ЗТХЯ
3.	Нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэрт зохицуулах, зохион байгуулах;	Аймаг хооронд, орон нутаг, аймгийн төв, хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийг тогтоох, өөрчлөх шийдвэрийг тухайн аймаг, хотын Засаг дарга гаргах бөгөөд аймаг, нийслэлийн Засаг даргын эрх олгосон байгууллага хэрэгжүүлэх	НИТХ, НЗДТГ, ТЦА-ын ЗЦГ, ЗХУТ
		Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, холбогдох байгууллагыг байнгын мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах	ЗТХЯ, НМХГ
		Хүн амын нутагшил, байршлын онцлог, зорчигч ба шуудан тээвэрлэлтийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй чиглэлд орон нутагт зорчигч, шуудан тээвэрлэлтийг зохих нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгээр тээвэрлэгчтэй гэрээ хийж гүйцэтгүүлэх	НИТХ, НЗДТГ, НТҮ-ийн ААН




## Алхам 2. Оролцогч талуудыг тодорхойлох.

Холбогдогч талуудыг тодорхойлохдоо Нийслэлийн Нийтийн тээврийн газар нь бусад байгууллагатай харилцах эрх хэмжээг үндэслэсэн болно. Үүнд:

- 1).Дээшээ чиглэлд дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ажлынхаа үр дүнг тайлагнах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, зөвлөгөө дэмжлэг авах;
- 2).Хэвтээ чиглэлд үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, хамтран ажиллах, саналаа уламжлах, мэргэжил арга зүйн дэмжлэг авах;
- 3).Доошоо чиглэлд нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, иргэдийн саналыг сонсох, үйлчилгээ үзүүлэх, эргэх холбоогоор хангах зэрэг хэлбэрээр харилцдаг болно.

Нийслэлийн Нийтийн тээврийн газрын үйл ажиллагаанд холбогдогч талуудыг дараах зурагт үзүүлэв.

**Зураг 1.** Оролцогч талууд



Нийслэлийн Нийтийн тээврийн газрын үйл ажиллагаанд холбогдогч талуудын оролцоог мэдээлэх, зөвлөх, санал өгөх, хамтран ажиллах, шийдвэр гаргах гэсэн ерөнхий ангиллын хүрээнд тодорхойлсон болно. Үүнийг дараах хүснэгтээр харуулав.

#### Хүснэгт 4. Оролцогч талуудын оролцоо

Холбогдогч талууд	ОРОЛЦОО					
	Мэдээлэх	Зөвлөх, эргэх холбоогоор хангах	Санал өгөх	Хамтран ажиллах	Шийдвэр гаргах	Бусад
УИХ					√	
ЗГ					√	
Зам тээврийн хөгжлийн яам		√		√	√	
Бусад яам		√			√	
Нийслэлийн ИТХ		√			√	
Захирагчийн ажлын алба		√		√	√	
Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд	√		√	√		
Нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүд	√		√	√		
Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжүүд	√		√	√		
Сургалт судалгааны байгууллагууд	√		√	√		
Иргэд	√		√	√		

**Алхам 3.** Чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлох. Нийслэлийн Нийтийн тээврийн газрын чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлохдоо холбогдогч талуудаас авсан санал асуулгын судалгааны дүнг үндэслэсэн. Санал асуулгад харьяа байгууллагын нийт 79 хүн хамрагдсан болно.

Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан ЧИГ ҮҮРЭГ ДАХИН ХУВААРИЛАХ АРГАЧЛАЛ-ын 3 дугаар хавсралтад заагдсан санал асуулга авах загвар маягтын дагуу санал асуулга авсан.

Санал асуулгыг GOOGLE FORM ашиглан богино хугацаанд гүйцэтгэсэн.

**Зураг 2.** Google form-аар авсан чиг үүрэг дахин хуваарилах аргачлалын маягтын дагуу боловсруулсан санал асуулгын загвар

## НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН ЧИГ ҮҮРГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ САНАЛ АСУУЛГА

Энэхүү санал асуулгын зорилго нь чиг үүргийн одоогийн хуваарилалт, түүний хэрэгжилтийн талаарх төрийн албан хаагчийн үнэлэмжийг тодорхойлж улмаар чиг үүргийг дахин оновчтой хуваарилах санал боловсруулахад шаардлагатай мэдээллийг цуглуулахад оршино.

Дараах асуултыг анхааралтай уншиж, өөрийн сонгосон хариултын өмнөх дугаарыг дугуйлах буюу хариултыг нөхөж бичнэ үү.

Нийтийн тээврийн газрын ... хэлтэс. \*

Ажилладаг хэлтэс, нэгжээ сонгоно уу

- Ачаа тээвэр, логистикийн хэлтэс
- Захиргаа, удирдлагын хэлтэс
- Зорчигч, тээврийн үйлчилгээний хэлтэс
  
- Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс
- Техник, технологийн хэлтэс
  
- Тээвэр, төлөвлөлтийн хэлтэс
- Хяналт шалгалтын хэлтэс

**Зураг 3.** Google form-аар авсан чиг үүрэг дахин хуваарилах аргачлалын маягтын дагуу боловсруулсан санал асуулгын загвар

5. Танай байгууллагын үндсэн чиг үүрэг ямар дэд чиг үүргээс бүрддэг вэ?(дэд чиг үүргүүдийн нэршлийг өөрийн бодлоор томъёолно уу) \*

Short answer text

7. Танай байгууллагын үндсэн болон дэд чиг үүргийн (үйлчилгээ) хэрэгжилтэд шаардагдах санхүүжилт хангалттай байдаг уу? \*

тийм

үгүй

:::

Хэрэв үгүй бол ямар үндсэн болон дэд чиг үүргүүдийн санхүүжилт хангалтгүй байдаг вэ? (нэрлэнэ үү)


Short answer text

8. Хуулиар танай байгууллага хэрэгжүүлэхээр тогтоосон боловч огт хэрэгждэггүй, эсхүл хангалтгүй хэрэгждэг үндсэн болон дэд чиг үүрэг (үйлчилгээ) байдаг уу? \*

тийм

үгүй

**Зураг 4.** Google form-аар авсан санал асуулгын дүн 1



**Зураг 5.** Google form-аар авсан санал асуулгын дүн 2



## Зураг 6. Санал асуулгад оролцогчид



## Хүснэгт 5. Чиг үүргийн үнэлгээ

дд	Үндсэн чиг үүргийн хэрэгжилтийн үнэлгээ	Холбогдогч талуудын үнэлгээ (хувь)
1	Автотээврийн талаар төрөөс баримтлах бодлоготой уялдуулан тухайн нутаг дэвсгэрт автотээврийн талаар баримтлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;	80
2	Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран нутаг дэвсгэртээ автотээврийн улсын хяналт хэрэгжүүлэх;	65
3	Нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэрт зохицуулах, зохион байгуулах;	98

## Алхам 4. Нийслэлийн Засаг даргаас Нийтийн тээврийн газарт олгосон захиргааны эрх хэмжээ

Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан чиг үүрэг дахин хуваарилах аргачлалд заасны дагуу Нийслэлийн Засаг даргын эрх хэмжээг тодорхойлохдоо дараах ангиллыг баримтлав. Үүнд:

1. Бодлого боловсруулах: Үндэсний хэмжээний болон салбар, орон нутгийн урт, дунд, богино хугацааны стратеги зорилт боловсруулах, төлөвлөх, хууль тогтоомжийн төсөл, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандарт тогтоох, бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийх чиглэлээрх Засгийн газар, яамд болон нутгийн удирдлагын байгууллагуудын эрх хэмжээ хамаарна.

2. Зохицуулалт хийх: Тодорхой үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр төрийн байгууллагаас зөвшөөрөл, лиценз, магадлан итгэмжлэх, гэрчилгээ олгох зэрэг эрх хэмжээ хамаарна.
3. Зохион байгуулах: Тухайн шатны төрийн байгууллагад хуулиар тогтоож өгсөн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг удирдан чиглүүлэх эрх хэмжээ хамаарна.
4. Санхүүжилт: Төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллагуудын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, санхүүгийн дэмжлэг, зардал, хөрөнгө оруулалттай холбоотой эрх хэмжээ хамаарна.
5. Хүний нөөцийн бодлого: Удирдах албан тушаалтан болон албан хаагчдыг томилох, чөлөөлөх, чадавхжуулах, бэлтгэх, давтан сургах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх зэрэг эрх хэмжээ хамаарна.
6. Хяналт шинжилгээ, үнэлгээ: Төрийн байгууллагын дэвшүүлсэн зорилт, түүний хэрэгжилт, хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэх, ажлын чанар, гүйцэтгэлд хяналт шалгалт болон дотоод аудит хийх эрх хэмжээ хамаарна.
7. Үйлчилгээ үзүүлэх: Төрөөс үзүүлэх үйлчилгээг төрийн байгууллага болон нутгийн удирдлагын байгууллага, эсхүл гэрээний үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх хэмжээ хамаарна.

#### Хүснэгт 6. Захиргааны хэм хэмжээ

Захиргааны эрх хэмжээ								
Д/д	Чиг үүрэг	Бодлого боловсруулах	Зохицуулалт хийх	Зохион байгуулах	Санхүүжилт	Хүний нөөцийн бодлого	Хяналт шинжилгээ үнэлгээ	Үйлчилгээ үзүүлэх
1	Автотээврийн талаар төрөөс баримтлах бодлоготой уялдуулан тухайн нутаг дэвсгэрт автотээврийн талаар баримтлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;	+		+	+	+	+	+
2	Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран нутаг дэвсгэртээ автотээврийн улсын хяналт хэрэгжүүлэх;	+		+	+	+	+	+
3	Нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэрт зохицуулах, зохион байгуулах;	+	+	+	+	+	+	+

## ГУРАВ. АЛСЫН ХАРАА

АЛСЫН ХАРАА:

**БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ, АЮУЛГҮЙ, ЗОРЧИГЧ ТӨВТЭЙ ТЭЭВЭРЛЭЛТИЙГ ГҮЙЦЭТГЭНЭ.**

УРИА:

**ТАНЫ ТАВ ТУХТАЙ ЗОРЧИЛТ, БИДНИЙ ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ**

## ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

**“НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР” НЬ НИЙСЛЭЛ ХОТЫН ТЭЭВРИЙН САЛБАРТ ОРЧИН ҮЕИЙН ДЭВШИЛТЭТ ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭХ ЗАМААР ИРГЭДЭЭ ДЭЭДЭЛСЭН ТЭЭВРИЙН СИСТЕМИЙГ БИЙ БОЛГОНО.**

## ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Орчны шинжилгээний үндсэн зорилго нь нийтийн тээврийн үйлчилгээний нөхцөл байдлыг судалж, гадаад, дотоод орчны талаарх мэдээллийг цуглуулж, түүнд дүн шинжилгээ хийх замаар хөгжлийн чиг хандлагыг тодорхойлно.

Орчны шинжилгээг хийхдээ статистик мэдээлэл, тухайн салбар, байгууллагын үйл ажиллагааны өнгөрсөн 4 жилийн тайлан, жил, улирлын гүйцэтгэлийн, төсөв санхүүгийн тайлангууд болон мандатын шинжилгээний хүрээнд хийгдсэн гадагш, дотогш чиглэсэн харилцааны хүрээнд холбогдогч талууд болох харьяа байгууллагын нийт 79 хүнийг хамруулан хийгдсэн асуулга судалгааны үр дүн, мэдээлэлд үндэслэн SWOT шинжилгээний аргыг ашиглан гүйцэтгэсэн болно. SWOT шинжилгээний арга нь үйл ажиллагааны одоогийн дүр төрхийг тодорхойлж, давуу ба сул тал, боломж, аюул заналаар дамжуулан цаашид хөгжүүлэх арга замыг тодорхойлон гаргадаг.

Тиймээс SWOT шинжилгээг нийтийн тээврийн газрын дотоод болон гадаад орчны хүчин зүйлсийг тодорхойлоход голлон чиглэсэн. Үүнд:

Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар **1,189** тээврийн хэрэгсэл байгаа бөгөөд дундаж насжилт **9.5** жил байна. Нийтийн тээврийн үйлчилгээнд нийслэлийн өмчийн 2, хувийн хэвшлийн 17 аж ахуйн нэгж үндсэн 101 чиглэлд нийт 972 их багтаамжийн автобус, троллейбусаар өдөрт 550-600 мянган зорчигчдод үйлчилж байна .

Ангилал ба үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага, стандартын дагуу нийтийн тээврийн үйлчилгээнд үйлдвэрлэгдсэнээс хойш 12 жил ашиглагдсан тээврийн хэрэгсэл ашиглахыг хориглодог бөгөөд 2020 онд 133 автобус, 2021 онд **531** автобус, 2022 онд **121** автобус, 2023 онд **151** автобус, 2024 онд **60** автобус нийт **81.7** хувь нь үйлчилгээнээс хасагдахаар байна. **2021** онд орон нутгийн өмчит байгууллагаас **250** ширхэг, хувийн хэвшлийн **280** ширхэг нийт **530** тээврийн хэрэгсэл насжилт дуусаж ашиглалтаас хасагдах тул нийтийн тээврийн парк шинэчлэлтийн төсөл нь нэн тэргүүний шаардлагатай төслүүдийн нэг юм.

2018-2020 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:

- 2019 онд МОН-30 Монголд үйлдвэрлэсэн 2 автобус,



- 2020 онд БНХАУ-аас 10 цахилгаан автобусыг авч туршилтаар Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглаж байна.
- 2020 онд сургуулийн хүүхдийн автобус нийт 75-ийг авахаас эхний ээлжинд 5 ш автобусыг 10 дугаар сард оруулж ирсэн.


Нийтийн тээврийн үйлчилгээнд нийт 1169 зогсоол ашиглагдаж байгаагаас эцсийн 59, дундын 1110 зогсоол байна. Нийслэлийн нутаг дэвсгэрт нэр бүхий 19 байршилд автобусны зогсоолын байгууламж барих төслийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлж байна. Улаанбаатарын бүсийн доторх хаяа дагуул хот суурингууд, дорвитой хөгжиж чадахгүй байгаагийн улмаас логистикийн үйл ажиллагаа сул хөгжсөн.

Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэхээр зөвшөөрөл авч замын хөдөлгөөнд оролцсон 14 мянга гаруй ачааны автомашин байна./Хагас жилээр/

### Хүснэгт 7. Салбарт хэрэгжиж буй төсөл арга хэмжээ

дд	Төслийн нэр	Хэрэгжих хугацаа	санхүүжилт		2022 онд санхүүжих	Хэрэгжилт
			дүн	Валют		
1	Нийслэлийн нийтийн тээвэрт агаарын дүүжин тээврийг нэвтрүүлэх төсөл	2020-2023	60.7 тэрбум	төгрөг	21255,8 сая	0%
2	Тулгуурт гүүрэн байгууламж бүхий шинэ төрлийн их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төсөл	2022-2024	19.5 тэрбум	Төгрөг	19.5 тэрбум	0%
3	Нийтийн тээврийн үйлчилгээний удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем	2015эхэлсэн	13,2 сая	Ам.доллар		70%

Зураг 7. Нийтийн тээврийн газрын бүтцийн схем.



Нийт бүрэлдэхүүн: 350 хүн

**Хүснэгт 8. Нийтийн тээврийн газрын орчны шинжилгээ - SWOT**

<b>ДОТООД ОРЧИН</b>	
<b>ДАВУУ ТАЛ</b>	<b>СУЛ ТАЛ</b>
<p>1.Нийтийн тээврийн үйлчилгээнд 2015 оноос Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем нэвтрүүлснээр тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналт сайжирсан.</p> <p>2.Нийтийн тээврийн үйлчилгээнд 2015 оноос Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем нэвтрүүлснээр төлбөр хураалтыг цахим хэлбэрт шилжүүлсэн.</p> <p>3.Өнөөдрийн байдлаар 17 ААН-ийн 1300 орчим тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй байна.</p> <p>4.Нийтийн тээврийн үйлчилгээний MNS 5012-2021 стандарт 2021 онд, Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрэм, Автотээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх дүрэм 2020 онд шинэчлэн батлагдсан.</p> <p>5.Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ААН-үүдийн 95 хувь нь MNS 5012-2021 стандартын шаардлагыг хангасан битүү, дулаан зогсоолтой болсон.</p> <p>6.Таксийн үйлчилгээнд 8 ААН-ийн 373 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй ажилладаг бөгөөд GPS систем суурилуулж хөдөлгөөний хянах боломжтой болсон.</p> <p>7.Цахим төлбөрийн картаа цэнэглэх 3 төрлийн аргыг хэлбэрийг нэвтрүүлсэн. Үүнд: -Автобусны зогсоол дээрх болон үйлчилгээний төвүүдийн цэнэглэх цэгээр - Автобусны зогсоол дээр ажиллаж байгаа шалгагч, хяналтын ажилтнаар -Гар утасны аппликейшн ашиглан өөрөө</p> <p>8.Нийслэлийн ихэнх иргэд гар утас, цахим технологийг ашигладаг болсон тул нийтийн тээврийн үйлчилгээгээр зорчих картаа гар утасны аппликейшн ашиглан цэнэглэх боломжтой болсон.</p>	<p>1.Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа автобусны насжилт өндөр болсон.</p> <p>2.Нийслэл орон нутгийн өмчит 2 байгууллагын тээврийн хэрэгслийн насжилт 12 жилээс дээш болж, өнгөрсөн жилийн 12 дугаар сарын 31-нээр стандартын дагуу үйлчилгээнээс хасагдах байсан тээврийн хэрэгслүүдийг үйлчилгээнд ашиглаж байгаа.</p> <p>3.2021 оноос нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах жолоочийн хомсдол бий болсон.</p> <p>4.Ур чадвартай жолооч нар цалин өндөр салбар руу шилжиж байгаатай холбогдуулан нийтийн тээврийн салбарт ур чадвартай, дадлага туршлага жолоочийн дутагдалд орсон.</p> <p>5.Мэргэжилтэй, боловсон хүчний дутагдалд орж байгаа.</p> <p>6.Автозамын хөдөлгөөний түгжрэлээс шалтгаалан үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурд буурсан.</p> <p>7.Цахим төлбөрийн картаар бус бэлэн мөнгийг жолоочид өгч зорчих зөрчил ихэссэн.</p> <p>8.Түлш шатахууны үнэ өссөнөөс шалтгаалан зардал өндөр болсон.</p> <p>9.Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэл хяналт Улаанбаатар смарт карт ХХК гэх 1 компаниас бүрэн хамааралтай болсон.</p> <p>10.Нийтийн тээврийн үйлчилгээгээр зорчигчдын хэрэглээний боловсрол бүрэн бус, цахим технологийн хэрэглээ хэвшил дадал бүрэн төлөвшөөгүй.</p> <p>11.Нийтийн тээврийн үйлчилгээний төлбөр хураах арга хэлбэр нь зөвхөн цахимаар төлөх боломжтой байгаагаас бэлэн мөнгөөр зорчиж буй иргэдээс хураах</p>

9.Сүүлийн жилүүдэд цахимаар картаа цэнэглэх байдал нэмэгдэж байгаа. 10. Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэж замын хөдөлгөөнд оролцдог ачааны автомашины талаар судалгаатай болсон.

10.Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд ангилал тогтоож, мэдээллийн сантай болсон.

11.Өглөө, оройны ачаалал ихтэй цагуудаар дундын зогсоолуудаас тээврийн хэрэгслийн эх авхуулах зохицуулалт хийсэн.

12.Хүлээгдлийн хугацааг бууруулахын тулд нийтийн тээврийн зарим чиглэлийг богиносгох төлөвлөлтийг хэрэгжүүлнэ

12.Салбарын хэмжээнд цалингийн дундаж түвшин нь доогуур байгаа. 13. Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэж хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгсэлд хяналт тавих ажлыг цахим хэлбэрт оруулаагүй.

13.Авто замын түгжрэлээс шалтгаалан нийтийн тээврийн цагийн хуваарь мөрдөгдөхгүй байна.

14.Нэгдүгээр эгнээгээр чиглэлийн тээврийн хэрэгсэл явах захирамж хэрэгжихгүй байна.

#### ГАДААД ОРЧИН

##### БОЛОМЖ

1.Нийслэлийн ихэнх иргэд гар утас, цахим технологийг ашигладаг болсон тул нийтийн тээврийн үйлчилгээгээр зорчих картаа гар утасны аппликейшн ашиглан цэнэглэх боломжтой болно.

2.Бэлэн мөнгө таних тодорхой технологийн шийдлийг нэвтрүүлж бэлэн мөнгөөр зорчилт хийж байгаа орлогыг нийтийн тээврийн үйлчилгээний санд төвлөрүүлэх боломжтой.

3.Цахим технологийн хөгжилд нийцүүлэн бүх зорчигчдод нийтийн тээврийн үйлчилгээний талаарх мэдээллийг тогтмол хүргэх боломжтой.

4.Нийтийн тээврийн хэрэгслийн парк шинэчлэлтийн асуудал Монгол Улсын Засгийн түвшинд яригдаж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсэн нь тээврийн хэрэгслийн насжилтыг бууруулах боломжийг бүрдүүлсэн.

5.Нийтийн тээврийн багтаамж ихтэй төрлийг нэвтрүүлэх судалгааны ажлууд хийгдэж эхэлсэн тул ойрын хугацаанд хэрэгжүүлж эхлэх боломжтой.

##### ЭРСДЭЛ

1.Түлш шатахууны үнэ өссөнөөс шалтгаалан зардал өндөр болж Нийслэлийн төсөвт дарамт учруулна.

2.Парк шинэчлэлт хийгдэхгүй удвал нийтийн тээврийн үйлчилгээ зогсонги байдалд орох эрсдэлтэй.

3.Бэлэн мөнгөөр зорчих зохицуулалтын дагуу тодорхой шийдэл гаргахгүй бол цахим картын зорчилт буурч, нийтийн тээврийн үйлчилгээний шугамын орлогогүй болох эрсдэлтэй

4.Хотын төвлөрлийг бууруулах, замын хөдөлгөөний түгжрэл саатлыг нэн яаралтай арилгахгүй бол нийтийн тээврийн үйлчилгээний дундаж хурд 5 км/ц-аас доош болж, цаашид зогсонги байдалд орох эрсдэлтэй.

## ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/667 дугаар захирамжаар “Нийслэлийн 2021-2024 онуудын стратеги төлөвлөгөө”-г баталсан. Уг төлөвлөгөөнөөс үзвэл нийслэл нь “тогтворжилтын стратеги”-ийг баримталж ажиллахаар тогтсон байдаг.

Тогтворжилтын стратеги нь байгууллагын ерөнхий үйл ажиллагааны тогтворжилтод анхаарч, үйлчилгээний чанарыг сайжруулж, өсч хөгжих, байр сууриа хадгалан төрөөс баримталж буй бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, Нийслэл нь тогтворжилтын стратегийн хүрээнд сул талаа бууруулж боломжийг нэмэгдүүлэх, давуу талдаа тулгуурлан эрсдэлд өртөхгүй байхаар зорилго, үйл ажиллагаагаа төлөвлөж ажиллах юм. Нийтийн тээврийн газар ч мөн адил одоо байгаа түвшингээ бууруулахгүйгээр цаашид улам илүү боловсронгуй болж хөгжих тогтворжилтын стратеги баримталж ажиллана.

Нийтийн тээврийн газрын стратеги төлөвлөгөөний хүрээнд дараах стратегийн зорилгыг дэвшүүлэв. Үүнд:

Стратегийн ЗОРИЛГО 1:	Боловсон хүчний хангалт, хүний хөгжлийн зорилтот түвшинг бүрэн хангана.
Стратегийн зорилго 2:	Материаллаг бааз, суурьшил, эдийн засгийн зорилтот түвшинг бүрэн хангана.
Стратегийн зорилго 3:	Байгальд ээлтэй, цахимжсан, шинэ технологи нэвтрүүлэх зорилтот түвшинг бүрэн хангана.

Нийслэлийн стратегийн зорилго, зорилт ба хариуцах байгууллага, нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог дараах байдлаар хангаж ажиллана.

Зураг 8. Стратегийн уялдаа



## ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

Нийтийн тээврийн газрын стратегийн зорилго, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг дараах хэсэгт харуулав.

**Хүснэгт 9.** Стратегийн зорилго, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин

### СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1.

дд	Стратегийн зорилго, зорилт	Стратеги	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Шалгуур үзүүлэлтийн утга			
					Суурь он	Суурь түвшин	Зорилтот он	Зорилтот түвшин
1	Халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг даван туулна		Цар тахлаас үүдэлтэй үйл ажиллагаа нь зогссон аж ахуйн нэгж	тоо	2021		2024	

### СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2.

дд	Стратегийн зорилго, зорилт	Стратеги	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Шалгуур үзүүлэлтийн утга			
					Суурь он	Суурь түвшин	Зорилтот он	Зорилтот түвшин
1	Салбарын болон байгууллагын ажилтан албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг зорилтот түвшинд хүргэнэ	Сурах эрмэлзлийг дэмжих	Зохион байгуулсан сургалтад хамрагдсан хүний тоо	тоо	2021		2024	
2	Залуучуудын хөгжилд чиглэсэн дэмжлэгийг зорилтот түвшинд хүргэнэ.	Ажлын зөв дадал, хандлагыг дэмжих	Залуучуудын хөгжлийн төвөөс зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан залуучуудын тоо	тоо	2021		2024	

**СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3.**

дд	Стратегийн зорилго, зорилт	Стратеги	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Шалгуур үзүүлэлтийн утга			
					Суурь он	Суурь түвшин	Зорилтот он	Зорилтот түвшин
1	Тээвэр логистикийн сүлжээг зорилтод түшинд хүргэнэ	Төр , хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих	Баруун, зүүн ачааны логистик төв барилга, байгууламж	хувь	2021	0	2024	30

**СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 4.**

дд	Стратегийн зорилго, зорилт	Стратеги	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Шалгуур үзүүлэлтийн утга			
					Суурь он	Суурь түвшин	Зорилтот он	Зорилтот түвшин
1	Баганан тулгуурт хөнгөн галт тэргийг үйлчилгээнд нэвтрүүлнэ	Тээврийн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх	Ажлын явц	Хувь	2022	10	2024	90
2	Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлтийг олон улсын стандартад нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.	Шинэ тээврийн хэрэгслээр хангах	Тээврийн хэрэгслийн тоо	Тоо	2022	500	2024	1140
3	Хориглосон хязгаарласан гудамж руу ачаа тээвэрлэх тээврийн хэрэгсэлд “ТҮР” зөвшөөрөл олгох ажлыг цахимд шилжүүлнэ	Зөвшөөрлийг цахимжуулах	Цахимаар авсан зөвшөөрлийн эзлэх хувь	хувь	2021	30	2024	80

## НАЙМ. НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛ

### Хүснэгт 10. Стратегийн зураглал

АЛСЫН ХАРАА	БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ, АЮУЛГҮЙ, ЗОРЧИГЧ ТӨВТЭЙ ТЭЭВЭРЛЭЛТИЙГ ГҮЙЦЭТГЭНЭ.		
	ТАНЫ ТАВ ТУХТАЙ ЗОРЧИЛТ, БИДНИЙ ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ		
ЭРХЭМ ЗОРИЛГО	“НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР” НЬ НИЙСЛЭЛ ХОТЫН ТЭЭВРИЙН САЛБАРТ ОРЧИН ҮЕИЙН ДЭВШИЛТЭТ ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭХ ЗАМААР ИРГЭДЭЭ ДЭЭДЭЛСЭН ТЭЭВРИЙН СИСТЕМИЙГ БИЙ БОЛГОНО		
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	Боловсон хүчний хангалт, хүний хөгжлийн зорилтот түвшинг бүрэн хангана.	Материаллаг бааз, суурьшил, эдийн засгийн зорилтот түвшинг бүрэн хангана.	Байгальд ээлтэй, цахимжсан, шинэ технологи нэвтрүүлэх зорилтот түвшинг бүрэн хангана.
СТРАТЕГИЙН ЗОРИЛТ	1.Салбарын болон байгууллагын ажилтан албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг зорилтот түвшинд хүргэнэ 2.Залуучуудын хөгжилд чиглэсэн дэмжлэгийг зорилтот түвшинд хүргэнэ.	1.Тээвэр логистикийн сүлжээг зорилтод түшинд хүргэнэ	1.Баганан тулгуурт хөнгөн галт тэргийг үйлчилгээнд нэвтрүүлнэ 2. Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлтийг олон улсын стандартад нийцүүлэн хийж гүйцэтгэнэ. 3.Хориглосон хязгаарласан гудамж руу ачаа тээвэрлэх тээврийн хэрэгсэлд “ТҮР” зөвшөөрөл олгох ажлыг цахимд шилжүүлнэ
ХАРИУЦАХ НЭГЖ	ЗУХ, ЗТҮХ, АТЛХ, ХШХ	ТеТХ, ТэТХ, ЗТҮХ, ХШХ, СХОХ, АТЛХ	ТеТХ, ТэТХ, ЗТҮХ, ХШХ, СХОХ, АТЛХ
	Нийтийн тээврийн газрын бүх хэлтэс нэгжүүд өөр өөрийн хариуцсан чиг үүргээр ороцоно.		
МАНДАТ	1. Автотээврийн талаар төрөөс баримтлах бодлоготой уялдуулан тухайн нутаг дэвсгэрт автотээврийн талаар баримтлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх; 2. Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран нутаг дэвсгэртээ автотээврийн улсын хяналт хэрэгжүүлэх; 3. Нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэрт зохицуулах, зохион байгуулах;		